



МОНГОЛ

УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС 2023

Funded by:



Federal Office
for Migration
and Refugees



НИЙТЛЭГЧ

International Organization For Migration (IOM) Germany

Charlottenstraße 68
10117 Berlin
Germany
T. +49 911 43 000
F. +49 911 43 00 260

iom-germany@iom.int
<https://germany.iom.int/>

This project is funded by the German Federal Office for Migration and Refugees (BAMF).



Federal Office
for Migration
and Refugees



The information contained in this Country Fact Sheet was researched with best intentions and care. However, IOM Germany assumes no responsibility or liability for any errors or omissions. Furthermore, IOM Germany cannot be held accountable for conclusions or decisions drawn from the information provided in this Country Fact Sheet.

For further information on voluntary return and reintegration, please visit the information portal www.ReturningfromGermany.de, or contact your local return and reintegration office.

© IOM August 2023 - Please note that information provided herein may be outdated due to dynamic developments in the country.

Агуулгын хүснэгт

1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

3. БАЙРНЫ АСУУДАЛ

4. НИЙГМИЙН ХАЛАМЖ

5. БОЛОВСРОЛ

6. ХҮҮХДҮҮД

7. ХОЛБОО БАРИХ

8. ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Эрүүл мэндийн үйлчилгээний талаарх ерөнхий мэдээлэл

Монгол Улс анхан шатны тусламж, нарийн мэргэжлийн үйлчилгээ гэсэн хоёр шатлал бүхий эрүүл мэндийн тогтолцоотой. Эрүүл мэндийн үйлчилгээг гурван төрлийн байгууллага (анхдагч, хоёрдогч, гуравдагч шатлал) болон засаг захиргааны хоёр хэлтэс (нийслэл, аймаг)-ээр дамжуулан үзүүлдэг. Өрхийн эрүүл мэндийн төв, сумын эмнэлэг, сум дундын эмнэлгүүдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж байна. Хоёрдогч шатлалын тусламжийг дүүрэг, аймгийн нэгдсэн эмнэлэг, хувийн эмнэлгүүд үзүүлж байна. Гуравдугаар шатлалын эрүүл мэндийн үйлчилгээг нийслэлд байрладаг олон төрөлжсөн төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд үзүүлдэг. 2023 оны байдлаар эрүүл мэндийн салбарт нийт 58.7 мянган ажиллагчид Монгол Улсад оршин суугаа 3 348 мянган хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Эрүүл мэндийн ажиллагчдын тоо сүүлийн 10 жилийн дунджаас 8.3 мянгаар буюу 10 000 хүн амд 13.5-оор, өмнөх онтой харьцуулахад 2.1 мянгаар буюу 10 000 хүн амд 3.6-оор тус тус нэмэгдсэн байна. Нийт ажиллагчдаас 92.6 хувь нь эрүүл мэндийн салбарын, 7.4 хувь нь бусад салбарын эрүүл мэндийн ажиллагчид эзэлж байна. Эрүүл мэндийн ажиллагчдаас их эмч 22.1, сувилагч 23.0, эм зүйч 5.0, бага эмч 3.1, удирдах ажилтан 2.2, лабораторийн техникч 2.3 хувийг тус тус эзэлж байна. Эмч, сувилагчийн харьцаа улсын түвшинд 1:1.0, Улаанбаатар хотод 1:0.9, аймгийн түвшинд 1:1.4 байна. Эмч, сувилагчийн харьцаа аймаг бүсүүдээр

ялгаатай байгаа ба хангай, баруун, зүүн бүсийн аймгуудад 1:1.4 байгаа бол төвийн бүсийн аймгуудад 1:1.2 байна. Хүн амын амбулаторт бүртгэгдсэн нийт өвчлөл сүүлийн 10 жилийн дунджаар 10 000 хүн ам тутамд 8469 байгаа ба 10 000 эрэгтэй хүн амд 6735, эмэгтэй хүн амд 10 154 байна.

Засгийн газраас эрүүл мэндийн салбарт төсөв төсөвлөдөг, нийт иргэдийн 90 гаруй хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаж байгаа ч 2014 оны нийт эрүүл мэндийн зардлын 42 хувийг иргэд хувиасаа төлсөн төлбөр эзэлж байна. Эрүүл мэндийн даатгалын шинэчлэл, эрүүл мэндийн 7 нпц даатгалын багцыг амбулаторийн үйлчилгээ болгон өргөжүүлэх, өндөр өртөгтэй оношилгоо, эмчилгээ, эмийн нөхөн олголт зэрэг нь 2011 онд эрүүл мэндийн даатгалд хамрагдаж хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний эзлэх хувь 66,3% байсныг 2016 онд 47,1% болгон бууруулжээ. Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх санаачилгын хүрээнд ДЭМБ-аас Монгол улсын засгийн газар болон орон нутгийн удирдлагуудад явуулын эрүүл мэндийн үйлчилгээ хүргэлтийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. Орчин үеийн явуулын эрүүл мэндийн технологи нь хөдөө орон нутгийн болон алслагдсан хүн амын бүлгүүдэд хүрэх зардал багатай арга хэрэгслээр хангадаг.

Эмнэлгийн байгууллага, эмчийн хүрэлцээ

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг Монгол Улсын бүх оршин суугчид үнэ төлбөргүй үзүүлж, засгийн газрын ерөнхий төсвийн орлогоос

1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

санхүүжүүлдэг. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хотод Өрхийн эрүүл мэндийн төв /ӨЭМТ/, хөдөө орон нутагт Сумын эрүүл мэндийн төв /СӨЭМТ/-өөр дамжуулан үзүүлж байна. ӨЭМТ-үүд нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хотуудын хороо бүрд, мөн аймгийн төвд байрладаг. ӨЭМТ-д дунджаар 4-6 өрхийн эмч, нэг эмчид нэг сувилагч оногдохоор ажилладаг.

2021 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 4 952 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 13, тусгай мэргэжлийн төв 15, бүсийн оношлогоо эмчилгээний төв 5, аймгийн нэгдсэн эмнэлэг 16, дүүргийн нэгдсэн эмнэлэг 4, нийгмийн эрүүл мэндийн төв 9, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 6, сумын эрүүл мэндийн төв 321, өрхийн эрүүл мэндийн төв 208, хувийн ортой эмнэлэг 239, хувийн клиник 1548 ажиллаж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Бүх СӨЭМТ 24 цагаар ажиллаж, сувилагч нар байнгын ээлжээр, багийн бага эмч нар гэрээр үзлэг хийдэг. Хамгийн гол нь сумын эмнэлгүүд эх барих зэрэг эх, хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлдэг. Төрөлжсөн эмнэлгүүд нийслэлд байрладаг бөгөөд тэдгээр нь нарийн мэргэшлийн, өндөр технологийн эмчилгээ, нөхөн сэргээхэд хэвтэн эмчлүүлэх болон амбулаторийн үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ нарийн мэргэжлийн эмч нар уруу явуулсан хүмүүст хоёрдогч шатны тусламжийн үүрэг гүйцэтгэдэг.

Монголд 1500 орчим хувийн эмнэлэг байдаг. Хувийн хэвшлийн эмнэлгүүд шүд, дотор, эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ, уламжлалт

анагаах ухаан, өндөр технологийн лабораторийн үйлчилгээ зэрэг хоёрдогч түвшний нарийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг. Эмчилгээний өртөг нь авсан үйлчилгээнээс хамаарна.

Яаралтай тусламжийг иргэн бүр үнэ төлбөргүй авах боломжтой. Хэн нэгэн яаралтай өвчин, гэмтэл, шарх авсан тохиолдолд хамгийн ойрын эмнэлэг яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлдэг.

Эрүүл мэндийн даатгал

Улсын эрүүл мэндийн даатгалд Монгол Улсын иргэн бүр заавал хамрагдах ёстой. Хөдөлмөр эрхэлж буй иргэдийн цалингаас цалингийн 4 хувьтай (үүнд ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь) тэнцэх хэмжээний шимтгэлийг автоматаар суутгадаг бол хувиараа хөдөлмөр эрхэлдэг эсвэл хөдөлмөр эрхэлдэггүй иргэд сайн дураараа тухайн жилийн цалингийн доод хэмжээний нэг хувьтай тэнцэх шимтгэлийг сар бүр төлдөг байна. Эрүүл мэндийн даатгалд 18-аас доош насны хүүхэд, тэтгэврийн иргэд, өндөр настан, халамжийн үйлчилгээнд хамрагддаг хүмүүс үнэ төлбөргүй хамрагдана. Мөн тэтгэврээс өөр орлогогүй, цэргийн албан хаагчид, 2-3 насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхчүүдэд хөнгөлөлт үзүүлдэг. Улсын эрүүл мэндийн даатгал хувийн эмнэлгүүдэд хамаарахгүй. Улсын эрүүл мэндийн даатгал хувийн эмнэлгүүдэд хамаарахгүй. Улсын эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг хариуцах үйлчилгээнд хэвтэн эмчлүүлэх үйлчилгээ, амбулаторийн үзлэг, хяналт, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ; өдрийн эмчилгээ, үйлчилгээ; өрх болон

1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх үйлчилгээ; хорт хавдрын химийн болон туяаны эмчилгээ; жирэмсний ба төрсний дараах үйлчилгээ; нөхөн сэргээх эмчилгээ; шүүх эмнэлгийн үйлчилгээ; эмчийн бичсэн жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт багтана. Мөн 5-10 хоног эмнэлэгт эсвэл сувилалд хэвтэх зардлыг улсын эрүүл мэндийн даатгалаас төлдөг.

Эмнэлгийн байгууллагад хандах

Өвдсөн хүн эхлээд ӨЭМТ-д хандаж, бүртгэлтэй өрхийн эмчид үзүүлэх шаардлагатай. Хэдийгээр эмчийн үзлэг төлбөргүй ч хувь хүн эмчийн бичсэн жороор эм авахдаа хувиасаа төлнө. Даатгалтай хүнд батлагдсан жагсаалтын дагуу зарим эмийг хөнгөлөлттэй үнээр олгодог. ӨЭМТ-ийн ажилтнууд өвчнийг эмчлэх боломжгүй тохиолдолд 13А маягтыг ашиглан дүүргийн эрүүл мэндийн байгууллагад шилжүүлж, илүү нарийвчилсан оношилгоо, нарийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг. Шаардлагатай бол гуравдугаар шатлалын эмнэлэгт шилжүүлж болно. Хөдөө орон нутагт дээрхтэй адил журмаар эхний холбогдох цэг нь сум, багийн эрүүл мэндийн төв байдаг. Хөдөө сумын эрүүл мэндийн төвүүд амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх үйлчилгээг үзүүлдэг. Алслагдсан малчид СЭМТ дэх багийн бага эмчтэй холбогдож болно. Амьдрал дээр малчид өөрсдөө дүүрэг, аймаг, гуравдугаар шатлалын эмнэлгүүдэд хандах нь олонтаа тохиолдоно. Өвчтөн өөрөө шилжин ирсэн тохиолдолд торгуулийн төлбөр төлөх шаардлагатай. Эмийн хүртээмж, өртөг: Нийт 36 орны

190 аж ахуйн нэгж, дотоодын эмийн үйлдвэрүүдээс 1502 нэр төрлийн эм бүртгэлтэй байна. Эмийн үнийн хөнгөлөлтийн хөтөлбөрийн журмын дагуу 362 гаруй эмийг нийгмийн эрүүл мэндийн даатгалаар нөхөн олгохоор баталсан. Даатгуулагч өвчтөн эмээ гэрээт эмийн сангаас хөнгөлөлттэй үнээр авдаг. Гэхдээ тэдгээр заалтыг үл харгалзан эмны олдоц ялангуяа хөдөө орон нутагт тааруу байх нь бий. Засгийн газар итгэмжлэгдсэн төлөөлөгчийн шалгалтаар тогтоогдсон орлоггүй хүмүүсийг даатгалын статусаас үл хамааран үнэ төлбөргүй эмээр хангадаг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Сүрьеэ, хорт хавдрын гурав, дөрөв дэх үе шат, сэтгэцийн эмгэг, удаан хугацааны эмчилгээ шаардлагатай чихрийн шижин, зарим дааврын эмгэг, эрхтэн шилжүүлэн суулгасны дараах эмчилгээ, бруцеллёз, глауком, ХДХВ/ДОХ зэрэг эрүүл мэндийн нөхцөл байдалд эмийн эмчилгээний зарим эмчилгээ үнэ төлбөргүй байдаг.

1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Эргэн ирсэн хүмүүст хүртээмжтэй байдал

Тавигдах шаардлага: Эрүүл мэндийн албан журмын даатгалыг ажилтан, ажил олгогчийн аль алины цалингийн шимтгэлээр санхүүжүүлдэг. Ажилтнууд цалингийнхаа 2 хувийг, ажил олгогч мөн 2 хувийг төлдөг. Сайн дураараа эрүүл мэндийн даатгалд хамрагдаж байгаа бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувийг төлнө. Тэтгэвэр авагч, оюутан, хүүхэд гэх мэт хөдөлмөр эрхэлдэггүй хүн амыг улсын нэгдсэн төсвийн орлогоор төлж хамруулдаг.

Гадаадаас эх орондоо эргэн ирж буй иргэн та улсын эрүүл мэндийн даатгалд хамрагдахыг хүсвэл Edaatgal апплекеишн-д бүртгүүлж, эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлөх боломжтой. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар та 2019 оноос хойших эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг сар бүр төлсөн байх ёстой. Иймээс та 2019 оноос хойш шимтгэл төлөөгүй тохиолдолд жил бүрийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувьтай тэнцэх шимтгэлийг нөхөн төлөх шаардлагатай (Хүснэгт 1). Ингэснээр та улсын эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, улсын эмнэлэг, эрүүл мэндийн төвөөс үнэ төлбөргүй эрүүл мэндийн үйлчилгээг авах боломжтой болно.

Бүртгэлийн журам: Өмнөх жилүүдэд эрүүл мэндийн даатгалын картаар эрүүл мэндийн даатгалын төлбөрийг бүртгэх, хянах үйл ажиллагаа явуулдаг байсан. Өдгөө иргэд www.emd.gov.mn цахим хуудсаар дамжуулан онлайнаар бүртгүүлж, даатгалын төлөлтөө шалгаж, эрүүл мэндийн даатгалаа төлөх боломжтой болсон. Буцаж ирсэн хүн гадаадад амьдарч байхдаа төлөөгүй байсан бүх төлбөрөө бөөнөөр нь нөхөн төлж болно.

Эрүүл мэндийн албан журмын даатгалыг төлсний дараа Монгол Улсад буцаж ирсэн иргэд улсын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүрээнд улсын эмнэлгээс тусламж үйлчилгээ авах боломжтой. Ингэхийн тулд даатгалаас ашиг хүртэгчийн эрүүл мэндийн байдлыг мэргэжлийн эмнэлгийн ажилтнууд үнэлж, албан ёсны онош тавьж, үүний үндсэн дээр буцаж ирсэн хүнийг мэргэжлийн эмнэлэгт шилжүүлж, цаашдын эмчилгээнд оруулна.

Бүрдүүлэх бичиг баримт: Монгол Улсын эрүүл мэндийн байгууллагад бүртгүүлэхдээ иргэний үнэмлэхний хуулбарыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт үзүүлж, статусаа шалгуулан, эрүүл мэндийн заавал төлөх даатгалд хамрагдах шаардлагатай.

2 ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хөдөлмөрийн зах зээлийн талаарх ерөнхий мэдээлэл

Хөдөө орон нутагт ажиллах боломж хомс байгаагаас гадна Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл нь тодорхой салбарт ур чадвартай ажилтан хомс, ур чадварын эрэлт нийлүүлэлт хоорондоо таарахгүй, улирлын болон түр ажил эрхлэлтээс хамааралтай байдал, жендэрийн тэгш бус байдал, тодорхой насны (нэн залуу болон 40 ба түүнээс дээш насныхан) бүлгүүдэд зориулсан хөдөлмөрийн зах зээлийн тодорхой тулгамдсан асуудлуудтай тулгарч байна. Түүнчлэн эдийн засгийн идэвхтэй хүмүүсийн бараг гуравны нэг нь ажилладаг хөдөө аж ахуйн салбарт бүтээмж, цалин, хөлс харьцангуй бага. Эрс тэс уур амьсгалын улмаас олон салбарт ажлын байр улирлын чанартай. Ажил эрхлэлтийн түвшин 2021 оны дөрөвдүгээр улиралд 53.6 болжээ (www.1212.mn). 2018 онд нийт хүн амын 7.8 хувь нь ажилгүй байв. Эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдээс 0.7 хувийн пунктээр илүү байна. Эмэгтэйчүүдийн дийлэнх хувь нь, ялангуяа хөдөө орон нутагт – гэрийн цалин хөлсгүй ажил гэх мэт цалингүй ажилладаг. Үүнээс гадна эмэгтэйчүүд дунджаар эрэгтэйчүүдээс ойролцоогоор 10 хувиар бага цалин авдаг. Сарын дундаж цалин 2021 оны дөрөвдүгээр улирлын байдлаар 1068.1 мянган төгрөг байсан. Хамгийн өндөр орлогыг санхүү, даатгалын бизнес, гадаадын байгууллага, уул уурхайн салбарынхан олж байв. Сарын дундаж цалин хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, ан агнуурын салбарт хамгийн бага байв. Хөдөлмөр эрхлэлтийн гол салбарт хөдөө аж ахуй (30%), бөөний худалдаа, жижиглэнгийн худалдаа,

тээвэр (20%), төрийн захиргаа, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн ажил (18%), үйлчилгээ (9%), барилга (7%), уулуурхай, олборлох салбар (5%), цахилгаан, хий, усан хангамж (2%), мэргэжлийн урлаг, үзвэр үйлчилгээ (2%) багтаж байна. Эмэгтэйчүүд үйлчилгээний болон жижиглэнгийн худалдааны ажилтан, мэргэжилтэн, эрэгтэйчүүд дархан урлал, худалдааны ажилтан, үйлдвэр, машин механизмын оператороор ажиллах магадлал өндөр байна. Тодорхой ажил мэргэжлийн тархалт нь боловсролын түвшин, өрхийн ядуурлын байдал, байршлаас хамаарч ялгаатай байдаг. Дээд боловсролтой идэвхтэй насанд хүрэгчид ихэвчлэн мэргэжлийн ажил, хууль тогтоогч, ахлах албан тушаалтан, менежерээр ажилладаг. Бага боловсролтой хүмүүс голдуу газар тариалан эрхэлдэг. Энэ нь орлогогүй өрхийн 45% нь хөдөө аж ахуйд ажилладаг идэвхтэй насанд хүрэгчдэд мөн хамаарна. Монгол Улсад албан бус хөдөлмөр эрхлэлт ялангуяа малчид, өрхийн цалингүй ажилчид, уул уурхайн салбарт ажилладаг ажилчдын дунд өргөн тархсан байна. Хувиараа буюу цалингүй ажил гэж тодорхойлсон албан бус хөдөлмөр нийт ажлын байрны 39 хувийг эзэлж байна. Албан бус хөдөлмөр нь хөдөө орон нутагт зонхилох хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр (68 хувь) бөгөөд Улаанбаатар хотод хамгийн бага (18 хувь) байна. Хөдөө аж ахуй бол хөдөлмөр эрхлэлтийн хамгийн чухал салбар юм. Хэдийгээр барилгын салбар нийт ажлын байрны дөнгөж долоон хувийг эзэлдэг ч улирлын болон түр ажилчдын хувьд хамгийн чухал салбар юм.

2 хөдөлмөрийн зах зээл

Ажил олох

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам (ХНХЯ) хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого боловсруулах үүрэгтэй. ХНХЯ, аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтэс, Хөдөлмөрийн биржүүд төрийн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлдэг. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хувийн хэвшлийн Хөдөлмөрийн биржийн ажилтнууд (голчлон нийслэл хотод) ажилладаг. Захиргааны мэдээллийн нэгдсэн сан нь ажилгүйчүүд болон идэвхжүүлэх хөтөлбөрт оролцогчдын бүртгэлийг хөтөлдөг. Нэгдсэн мэдээллийн санд цуглуулдаг ажлын байрны мэдээлэлд оффисийн терминал болон интернетээр дамжуулан хялбархан хандах боломжтой. Засгийн газраас

малчид, 40-өөс дээш насны иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, мэргэжлийн ур чадвар дутмаг иргэд, дэмжлэг туслалцаа шаардлагатай бизнес эрхлэгчид, ажлын туршлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуучууд, МСҮТ төгсөгчид, богино хугацааны ажил хайж байгаа ажилгүй иргэдэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих есөн хөтөлбөрийг санал болгодог. Аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтсүүд нь мэргэшил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх; ажилд зуучлах үйлчилгээ, мэргэжлийн сургалт, давтан сургалт хийх, хувиараа хөдөлмөр эрхлэгч буюу нөхөрлөл, хоршоо хэлбэрээр бизнес эрхэлж буй иргэдийг дэмжих;



Photo: Unsplash/ Vince GX 2019

2 хөдөлмөрийн зах зээл

ажил олгогчид болон нийтийн ажилд дэмжлэг үзүүлэх ажлыг гүйцэтгэдэг. Мэргэжлийн сургалтыг улсын сургалтын байгууллагаар шууд эсвэл шууд бусаар тэтгэмж олгох замаар явуулдаг. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамрагдахын тулд ажилгүй иргэд оршин суугаа газрынхаа бүртгэлд хамрагдах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, Хөдөлмөрийн хэлтэс байрладаг газрын иргэдэд эдгээр үйлчилгээг үзүүлж байна. Хөдөлмөрийн зах зээлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудаас гадна Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо, Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Үйлдвэрчний Эвлэл, Хувиараа Хөдөлмөр Эрхлэлтийн Үндэсний Зөвлөл, ТББ зэрэг олон хувийн хэвшлийн байгууллага оролцож байна.

Ажилгүйдлийн тусламж

Ажилгүйдлийн тэтгэмж авахын тулд тухайн хүн 24-өөс доошгүй сар даатгалд хамрагдсан ажилтай байсан байх шаардлагатай бөгөөд үүнээс сүүлийн 6 сард нь тасралтгүй даатгал төлсөн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нутаг дэвсгэрийн хэлтэст бүртгүүлэх шаардлагатай. Тэтгэмжийг сүүлийн гурван сарын дундаж цалин, ажилласан хугацаанд үндэслэн тооцно.

Нэмэлт боловсрол, сургалт

Мэргэжлийн сургалт, ур чадвар дээшлүүлэх асуудлыг ХНХЯ, Боловсролын Яамнаас хариуцдаг. Төрийн 51, хувийн 35, нийтдээ 86 МСҮТ үйл ажиллагаа явуулж байна. МСҮТ-д

бүртгүүлэхийн тулд иргэд бүрэн дунд боловсрол эзэмшсэн байх ёстой. Насанд хүрэгчдэд зориулсан богино хугацааны сургалтанд боловсролын тусгай шаардлага тавьдаггүй.

Улсын хэмжээнд насан туршийн боловсрол, түүнтэй адилтгах өөр хөтөлбөр санал болгодог 355 Насан туршийн боловсролын төв байдаг. Насан туршийн боловсролын хөтөлбөрт амьдрах ухаан, гэр бүлийн боловсрол, иргэний боловсрол, ёс зүй, гоо зүйн боловсрол, шинжлэх ухааны боловсрол зэрэг багтана. Дүйцэх хөтөлбөрт бага, суурь, дунд боловсрол, амьдрах ухаанд суурилсан бичиг үсгийн хөтөлбөрүүд багтана.

Эргэн ирсэн хүмүүст хүртээмжтэй байдал

Тавигдах шаардлага: Ажилд орох хүсэлтэй, эргэн ирсэн иргэд оршин суугаа тухайн дүүрэг, хороонд очиж, ажилгүйчүүдийн бүртгэлд хамрагдах боломжтой. Мөн та нийслэл, дүүрэг, эсвэл сумын Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хандаж төрөөс хэрэгжүүлдэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдах боломжтой.

Бүртгэлийн журам: Дүүрэг, хорооны ажилтан буцаж ирсэн иргэнд таарсан ажлын байр байвал холбоо барина.

Бүртгүүлэх бичиг баримт: Эргэн ирсэн иргэн бүртгүүлэхдээ иргэний үнэмлэх эсвэл хүчинтэй оршин суух зөвшөөрлөө боловсрол, мэргэшлийг баталгаажуулсан бичиг баримтын хамт авчирна.

3 БАЙРНЫ АСУУДАЛ

Байрны талаарх ерөнхий мэдээлэл: Хотод байр түрээслэх өртөг хөдөө орон нутагтай харьцуулахад өндөр байдаг. Нийслэл Улаанбаатарт нэг унтлагын өрөөтэй байр түрээслэх дундаж зардал 2022 оны байдлаар ойролцоогоор 170-350 евро байна. Хоёр эсвэл гурван унтлагын өрөөтэй байрны түрээсийн үнэ нь байршил, орчны таатай нөхцлөөс хамааран 210-500 еврогийн хооронд байдаг. Бусад хот, сум, тосгон уруу нүүхэд өртөг нэлээд хямдарна.

Байр хайх

Ихэнх байрыг үл хөдлөх хөрөнгийн агентлагуудаар дамжуулан түрээслүүлдэг. Ихэвчлэн нэг сарын түрээсийг түрээслэгчээс барьцаа болгон авна. Түрээсийн гэрээг түрээслэгч болон түрээслэгчийн хооронд байгуулдаг. Хууль ёсны болгож, гэрээнд нотариатаар гарын үсэг зуруулж болно. Монголд байр худалдан авах, түрээслэхэд олон вэбсайтууд сонголтыг санал болгодог, жишээ нь: www.remax.mn, www.c21.mn, <https://www.osmo.mn/>, <https://eturees.mn/>. Мөн та Фейсбүүк зэрэг олон нийтийн сүлжээг ашиглан хувь хүнээс байр түрээслэх боломжтой.



Photo: Unsplash/ Duku Photography 2021

4 НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн тогтолцоо

Монгол Улсын нийгмийн халамжийн тогтолцоо нь өндөр настан, өнчин хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг орлогогүй, эмзэг бүлгийг дэмжих, хамгаалах, тэдэнд туслах зорилготой тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээнээс бүрддэг. Нийгмийн халамжийн тогтолцоонд 70 гаруй төрлийн шимтгэлгүй тэтгэмж олгодог бөгөөд нийт өрхүүдийн 40 орчим хувь нь хамрагдаж байна. Үүнд шимтгэл төлсөн тэтгэвэр, нийгмийн даатгалын тэтгэмж, Хүүхдийн Мөнгө Хөтөлбөр багтаагүй болно. Хүн амын хамгийн ядуу таван хувьд чиглэсэн “Хүнсний талон” хөтөлбөрийг эс тооцвол нийгмийн халамжийн тэтгэмжийн ихэнх нь тодорхой зорилтот бүлэгт чиглэгддэг.

Монгол Улсад хэрэгжиж байгаа нийгмийн халамжийн 72 хөтөлбөрийг (i) нийгмийн халамжийн тэтгэвэр, (ii) нийгмийн халамжийн тэтгэмж, (iii) олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, (iv) төрийн алдар цолтон ахмад настанд олгох нэмэгдэл, (v) өндөр настанд олгох тэтгэмж, (vi) хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох тэтгэмж, (vii) эх, хүүхдэд олгох тэтгэмж, (viii) хүнсний талон олгох хөтөлбөр (ХҮТ), (ix) хүүхдийн мөнгөний хөтөлбөр (ХМХ) гэж бүлэглэж болно. Хүнсний талон олгох болон Хүүхдийн мөнгөний хөтөлбөр нь орлого багатай иргэдэд ихээхэн дэмжлэг болдог.

Нийгмийн халамжийн тэтгэмжийг (i) үрчлэгдсэн хүүхдийг асран хүмүүжүүлдэг хүмүүс (ii) аюулгүй байдал, хамгаалалт шаардлагатай

хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд; (iii) асран халамжлах төрөл төрөгсөдгүй хөгжлийн бэрхшээлтэй хүн эсвэл өндөр настан; (iv) байнгын асаргаа шаардлагатай өвчтэй, өндөр настан эсвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэн; (v) жирэмсэн эхчүүдэд олгодог. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг сар бүр олгодог. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэтгэвэр, тэтгэмж олгох шалгуурыг аймаг, дүүргийн хэмжээнд эмнэлгийн болон нийгмийн хамгааллын комисс тогтоодог. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авах хүсэлтээ сум, хорооны нийгмийн халамжийн ажилтнуудад өгч, тухайлбал, эмнэлгийн карт, оношилгоо зэрэг дагалдах баримт бичгийг хавсаргах шаардлагатай. Өргөдөл, дагалдах бичиг баримтыг хүлээн авснаас хойш хуанлийн 30 хоногийн дотор нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох шийдвэрийг гаргана. Зөвшөөрөгдсөний дараа төлбөрийг тухайн хүний дансанд хийнэ. Онцгой тохиолдолд өргөдөл гаргагчийн нэрийн өмнөөс өөр хүн эсвэл нийгмийн ажилтан тэтгэвэр, тэтгэмжийг авч, түүнд бэлнээр хүргэж өгч болно.

Одоогийн мөрдөгдөж байгаа Нийгмийн халамжийн тухай хуулиар сум, хороонд ажиллаж байгаа нийгмийн халамжийн ажилтнууд нийгмийн халамж, тэтгэмжид хамрагдах эсэхийг тогтоогоод тухайн аймаг, дүүргийн Нийгмийн хамгааллын зөвлөлд шилжүүлдэг тогтолцоог бий болгосон байна. Гэхдээ тэдгээр үйлчилгээг зөвхөн сум, хороонд бүртгэлтэй иргэдэд үзүүлдэг.

4 НИЙГМИЙН ХАЛАМЖ

Эргэн ирсэн хүмүүст хүртээмжтэй байдал

Тавигдах шаардлага: Нийгмийн халамжийн тухай хуульд зааснаар өрхийн мэдээллийн санд бүртгэлтэй, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхөд амьдарч буй иргэн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжтой. Гол шалгуурт тэнцэх бүлгүүдэд өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, бүтэн өнчин хүүхдүүд, байнгын асаргаа шаардлагатай хүмүүс, өрх толгойлсон өрх толгойлсон эцэг эх багтана. Мөн өрхийн орлого, гишүүдийн тооноос хамаарч 18-аас доош насны хүүхэдтэй өрхүүд Хүүхдийн мөнгө хөтөлбөрт хамрагдах боломжтой. Хүнсний талон олгох хөтөлбөрт орлого багатай эсвэл огт орлогогүй зорилтот бүлгийн, хүн амын 5% хамрагддаг.

Бүртгэлийн журам: Иргэд нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдахын тулд харьяа хороо, сумын нийгмийн ажилтанд бүртгүүлж, орлогын түвшингийн үнэлгээнд хамрагдаж, нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагдах өргөдөл, иргэний үнэмлэхний хуулбарыг бүрдүүлнэ.

Бүрдүүлэх бичиг баримт: Буцаж ирсэн иргэн бүртгүүлэхдээ иргэний үнэмлэх эсвэл хүчинтэй оршин суух үнэмлэхээ боловсрол, мэргэшлийг баталгаажуулсан бичиг баримтын хамт авчирна.

Тэтгэврийн тогтолцоо

ТЭТГЭВЭР нь өндөр насны тэтгэвэр, тахир дутуугийн тэтгэвэр, болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр гэсэн

гурван төрөл байдаг ба даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, тахир дутуу болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ. Монгол Улсын өндөр насны тэтгэврийн тогтолцоо нь нийгмийн даатгал, нийгмийн халамжийн тэтгэврийн тогтолцооноос бүрддэг. Монгол Улс 1960 оноос өмнө төрсөн хүмүүст зориулсан Цалинд суурилсан тэтгэврийн тогтолцоо (ЦСТТ), 1960 оноос хойш төрсөн хүмүүст зориулсан Нэрийн дансны тогтолцоо (НДТ)-той. ЦСТТ схемийн хувьд тухайн хүн бүрэн тэтгэвэр авахын тулд хамгийн багадаа 20 жил, бууруулсан тэтгэвэр авах бол 10-20 жил шимтгэл төлсөн байх шаардлагатай. ЦСТТ-ны хувьд хамгийн бага тэтгэврийн шимтгэлийг 15-аас доошгүй жил төлсөн байх шаардлагатай. Өндөр насны тэтгэврийн тогтолцоо шинэчлэгдэж байгаатай холбогдуулан тэтгэврийн насыг эрэгтэй хүнд төрсөн он харгалзан 60-62, эмэгтэй хүнд 55-57, 4 ба түүнээс дээш хүүхэдтэй эх 50 гэж тогтоосон. Та өөрийн Өндөр насны тэтгэвэр тогтоох насны талаарх мэдээллийг ndaatgal.mn цахим хуудсаар авах боломжтой. Албан журмын даатгалын шимтгэлийн хувь хэмжээ хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 17 хувь (үүнд даатгуулагч 8,5%, ажил олгогч 8,5%) байна. Ажилгүй иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчид Нийгмийн Даатгалын Ерөнхий Газартай сайн

4 НИЙГМИЙН ХАЛАМЖ

дурын даатгалд хамрагдаж, жишиг орлогын 11.5 хувийг төлж болно. Тэтгэвэр тогтоолгох орлогын хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний хооронд байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам шимтгэлтэй (албан журмын болон сайн дурын) тэтгэврийн сангаас олгодог өндөр насны тэтгэмжээс гадна шимтгэл төлөөгүй эсвэл шимтгэлийн тэтгэвэр авахад ажилласан жил нь хүрэхгүй байгаа 55-аас дээш насны эмэгтэйчүүд, 60-аас дээш насны эрэгтэйчүүдэд шимтгэлгүй нийгмийн халамжийн тэтгэврийн тогтолцоог хэрэгжүүлдэг. ХНХЯ-ны Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Ерөнхий Газар нь нийгмийн халамжийн тэтгэвэр болон нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст чиглэсэн бусад нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Зорилтот бүлэг

Татвараас санхүүждэг нийгмийн халамжийн тогтолцоо нь нийгмийн зорилтот бүлгийн ахмад настан, өнчин хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, нялхас, амаржсан эхчүүд болон олон хүүхэдтэй өрх толгойлсон эхчүүдэд төрийн дэмжлэг үзүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Засгийн газар 2005 онд ядууралтай амьдарч буй хүмүүст чиглэсэн Хүүхдийн Мөнгө Хөтөлбөрийг (ХМХ) хэрэгжүүлж, 2010 оноос бүх хүүхдийг хамруулж байна. 2020 оны 5-р сард КОВИД-19-ийн үед хүүхэдтэй айл өрхийг дэмжих зорилгоор хүүхэд бүрт олгох хүүхдийн мөнгийг 20,000 төгрөг байсныг 100,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн. ХМХ-т хамрагдахын тулд тухайн хүүхдийг хороо, сумын нийгмийн халамжийн мэдээллийн санд бүртгүүлсэн байх шаардлагатай. Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг жирэмсэн эмэгтэйд үйл ажиллагаа, ажил эрхлэлтийн байдлаас үл хамааран 12 сарын хугацаанд олгоно.

Эргэн ирсэн хүмүүст хүртээмжтэй байдал

Тавигдах шаардлага: Монгол Улсын бүх иргэн шимтгэлийн болон нийгмийн халамжийн тэтгэврийн хөтөлбөрт хамрагдах боломжтой.

Бүртгэлийн журам, бичиг баримт: Тэтгэвэр тогтоолгох хүсэлтэй иргэд тухайн хүний шимтгэл төлсөн жил, нийгмийн даатгалын дугаар, иргэний үнэмлэхний дугаар бүхий нийгмийн даатгалын дэвтэр, иргэний үнэмлэхний хуулбар, ажлаас чөлөөлсөн тухай тушаал, шийдвэр зэргийн Нийгмийн даатгалын ерөнхий газарт авчирна.

Эргэн ирсэн хүмүүст хүртээмжтэй байдал

Тавигдах шаардлага: Монгол Улсын бүх иргэн шимтгэлийн болон нийгмийн халамжийн тэтгэврийн хөтөлбөрт хамрагдах боломжтой. Та өөрийн хороо, сумын нийгмийн ажилтантай хандах эсвэл Ehalamj.mn халамжийн нэгдсэн системээр дамжуулан халамжийн үйлчилгээг цахимаар авах боломжтой.

5 БОЛОВСРОЛ

Боловсролын талаарх ерөнхий мэдээлэл

Монгол улсын боловсролын тогтолцоо нь сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролоос бүрдэнэ. Монгол Улсын хэмжээнд 2020-2021 оны хичээлийн жилд нийт 1,454 хүүхдийн цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс төрийн өмчийн 948 цэцэрлэг (27 төмөр замын харьяа хүүхдийн цэцэрлэг), хувийн 506 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оноос 15 цэцэрлэг (төрийн 38 нэмэгдэж, хувийн 23 хасагдсан) нэмэгдсэн байна. Бага боловсрол нь 6 настайгаас эхэлж, 6 жил үргэлжилнэ. Дунд боловсрол нь 12-17 насны хүүхдүүдэд зориулагдсан бөгөөд бага дунд (7-9-р анги) болон бүрэн дунд (10-12-р анги) гэсэн шатлалаас бүрдэнэ. Монгол улсад багаас дунд боловсрол (1-9-р анги) хүртэлх боловсролыг заавал эзэмших ёстой гэж үздэг. Хичээлийн жил есдүгээр сард эхэлж, тавдугаар сард дуусна. Монгол Улсад бага, дунд, бүрэн дунд боловсролыг хуулиар үнэ төлбөргүй олгодог. Гэхдээ сурах бичиг, сурагчийн дүрэмт хувцасны зардлыг эцэг эх хариуцна. Сургуулийн өмнөх боловсрол үнэ төлбөргүй боловч хотын сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн 35.5 хувь, орон нутгийн 46.1 хувь нь (Олон үзүүлэлт бүхий кластер судалгаа (MICS), НҮБ-ын Хүүхдийн сан, 2018) цэцэрлэг хүрэлцээгүйн улмаас сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чадахгүй хэвээр байна. Цэцэрлэгүүд хамгийн дээд хүчин чадлаар ажиллаж, хамрагдах хүүхдийн тоо нь хэтэрсэн цэцэрлэгүүд сугалааны тохирол зохион байгуулдаг. Хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөн өндөр байгаатай холбоотойгоор сүүлийн хэдэн арван жилд томоохон хотуудын хүн ам ихээхэн өссөн байна. Улмаар боловсрол зэрэг нийгмийн үйлчилгээнд ирэх дарамт нэмэгдэж байна. Хотын захын дүүргүүдийн өдөрт 2-3 ээлжээр хичээллэдэг улсын сургуулиудад нэг багшид оногдох сурагчийн тоо их байна. Хотод шинээр сургууль байгуулж байгаа ч хөдөөгийн иргэд шилжин суурьшдаг хот, дүүргүүдэд сургууль хүрэлцэхгүй хэвээр.

Бүрэн дунд сургуульд сураагүй сурагчид мэргэжлийн болон ерөнхий бүрэн дунд боловсролыг хосолсон мэргэжлийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын (МСҮТ) сургуульд суралцах боломжтой. Тиймээс тэдгээр сургуулийг төгсөгчид их, дээд сургууль, коллежид шилжин суралцаж болно. Манай улсад үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо 2020-2021 оны хичээлийн жилд 88 байгаагийн 37 (42.1%) нь их сургууль, 45 (51.1%) нь дээд сургууль, 3 (3.4%) нь коллеж, 3 (3.4%) нь гадаадын их сургуулийн салбар байна. Үүний 65 (73.9 %) нь төрийн бус өмчийн, 20 (22.7 %) нь төрийн өмчийн, 3 (3.4%) нь олон нийтийн/шашны өмчийн сургууль байна. Нийт сургуулийн 79 (89.8%) нь Улаанбаатар хотод, 9 (10.2%) хөдөө, орон нутагт байна. Сургалтын төлбөр, зээл, тэтгэлэг: 2020-2021 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 839 сургуулиас 672 нь төрийн өмчийн сургууль, 167 нь хувийн сургууль байна. Ихэнх хувийн сургуулиуд хот суурин газарт төвлөрдөг бөгөөд тэдгээр сургуулиуд улсын сургуулиудтай харьцуулахад илүү сайн сургалтын хөтөлбөр санал болгож, чанартай сургалт явуулдаг. Хэдийгээр хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиуд Монголын боловсролын салбарын зарим ачааг үүрэлцэж, төрийн ажлыг хөнгөвчилдөг боловч сургалтын төлбөр өндөр байгаа нь боловсролын салбарт тэгш бус байдлыг бий болгож байна.

Засгийн газраас бага, дунд, бүрэн дунд боловсролын түвшинд хөгжлийн бэрхшээлтэй сурагч, оюутнуудад сурах бичиг, цүнх, бичиг хэргийн хангамж зэрэг санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Сургуулийн элсэлтийг оршин суух газар, сургууль, сургуулийн удирдлагуудын шийдвэрт үндэслэнэ. Харин Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг хүн ам шигүү суурьшсан газарт Боловсрол, Соёлын Газар мөн элсэлтийн шийдвэрт оролцдог.

5 БОЛОВСРОЛ

Гадаад дипломыг батлах, шалгах

2019 оны байдлаар гадаадад суралцахаар зорьж буй Монгол оюутнуудын дунд бүрэн дунд боловсролын гэрчилгээг хүлээн зөвшөөрөхгүй байх тохиолдол гарч байна. Их хэмжээний ялгаатай байдлаас шалтгаалан (жишээлбэл, сургалтын үргэлжлэх хугацаа эсвэл хөтөлбөрийн агуулгын хувьд) дасан зохицох дадлага сургуулилт/сургалт, ур чадварын шалгалт/зөрүү, давтагдсан хичээлийн жилийн шалгалт зэрэг нөхөн тэнцүүлэх арга хэмжээг санал болгосон байгаа.

Эргэн ирсэн хүмүүст хүртээмжтэй байдал

Тавигдах шаардлага: Сургууль, цэцэрлэгүүд хичээлийн жилээ 9-р сард эхлүүлж, шинээр ирсэн сурагчдыг ихэвчлэн 8-р сард бүртгэдэг. Сургууль, цэцэрлэгүүд өөрийн хамран сургах тойрогт амьдардаг, бүртгэлтэй хүүхдүүдийг бүртгэж байна. Өөрөөр хэлбэл, эцэг эхийн оршин суугаа хаяг нь сургууль, цэцэрлэгийн хамран сургах тойрогт байх ёстой.

Бүрдүүлэх бичиг баримт: Эргэн ирсэн хүүхдийг сургууль, цэцэрлэгт элсүүлэхийн тулд хүүхдийн төрсний гэрчилгээ, эцэг эхийн иргэний үнэмлэх шаардлагатай. Сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын сургалтын байгууллагын хамран сургах тойрог дотор харьяа сургуульд 6 нас хүрсэн бүх хүүхдийг нэгдүгээр ангид элсүүлэх журамтай.



Photo: Unsplash 2016/ Aaron Burden

6 ХҮҮХДҮҮД

Хүүхэд, нялхсын ерөнхий байдал

Монгол улс бол хүн амынх нь бараг гуравны нэгийг хүүхэд, өсвөр үеийнхэн бүрдүүлдэг залуу улс юм. Харин хүүхдүүдийн 28.9 хувь нь орлогогүй өрхөд амьдардаг бөгөөд тэдгээр хүүхдүүд амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой хүмүүсийн 46 хувийг эзэлж байна. Өргөн тархсан орлогын ядуурал нь хүүхдийн сайн сайхан байдлыг доройтуулдаг. Ядуурал нь хүүхдийн тоо, хараат байдлын харьцаатай ихээхэн холбоотой байдаг. Мөнгөний ядуурлаас гадна хүүхдийн гачигдалтай байдал олон талаараа өндөр, үүнд мэдээллийн хүртээмж, орон сууц, бага насны хүүхдийн хөгжлийн хувьд хамгийн өндөр, гачигдалтай хүн амын тоо ялангуяа хөдөөгийн хүүхдүүдийн хувьд өндөр байна.

Нялхсын эндэгдлийн түвшин (IMR) болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (U5MR) нь орлогын ядуурал ба хөдөөгийн сул талын нөлөөг харуулдаг. Олон үзүүлэлтийн кластер судалгаанаас (MICS, UNICEF, 2018) өрхийн хамгийн ядуу 20% дах IMR болон U5MR нь хамгийн чинээлэг 20%-ийнхаас 1.5 дахин их байна. IMR болон U5MR нь эхийн боловсролтой мөн холбоотой. Жишээлбэл, бага боловсролтой эх/асран хамгаалагчийн хүүхдүүдийн U5MR нь 35 бол коллеж/их дээд сургуулийн боловсролтой хүмүүсийн хувьд 11 байна. Монгол Улсад тулгарч буй гол сорилт бол тэгш бус байдал гэдгийг Хүний Эрхийн Хороо онцолсон байна. Монгол Улсын хувьд Жини коэффициент 32.7 (2018) байгаа нь шилжилтийн дараах орнуудын тэгш бус байдлын хамгийн өндөр үзүүлэлтүүдийн нэг юм.

Хүүхдийн хөгжилд сөргөөр нөлөөлдөг ядуурал, тэгш бус байдлаас гадна хөгжлийн бэрхшээл, үндэс угсаа, шилжин суугчийн статус зэрэг нь эмзэг байдлын бусад хүчин зүйлсэд багтдаг. Бүртгэлгүй, хотод шилжин ирэгсдийн хүүхдүүд тухайн газарт бүртгэлгүйгээсээ болж

эрүүл мэнд, боловсрол, хүүхэд хамгаалал болон нийгмийн бусад үйлчилгээг авах боломж хязгаарлагдмал. Казах, цаатан гэх мэт үндэстний цөөнх тэргүүлдэг айл өрхийн хүүхдүүдийг эрүүл мэнд, боловсрол, хамгаалалтай холбоотой шалгуур үзүүлэлтээр нь ядуу гэж үздэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломж хязгаарлагдмал, гадуурхал, ялгаварлалтад өртдөг. Тэдний бүх шатны боловсрол эзэмших байдал нь хязгаарлагдмал. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өнөөгийн боловсролын тогтолцоог ихэвчлэн Улаанбаатар хотод байрладаг төрөлжсөн сургууль (6), цэцэрлэг (2)-аар дамжуулан олгож байна. Тэгш хамруулан сургах боловсролыг бодлого, хууль тогтоомжоор дэмжиж байгаа ч сургуулиудад хүртээмжтэй орчин, багш нарын хангалттай сургалт, олон нийтийн дэмжлэг дутмаг байна.

Хүүхдийн эрхийг хангах, хүүхдийг бүрэн боломжоор нь хөгжүүлэхийн тулд төрөөс эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, хүүхэд хамгаалал, олон нийтийн хөгжил зэрэг олон салбарын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. 2016 онд УИХ-аар Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг баталсан. Мөн онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг баталж, хүүхдийг хүчирхийлэл, үл хайхрах, мөлжлөг, дайралтаас хамгаалах талаар тодорхой заалтуудыг тусгасан. Хүүхдийн тусламжийн 108 утас ажиллаж эхэлснээс хойш хүүхэд хамгаалалтай холбоотой тохиолдлууд ихээхэн өссөн. Нийгмийн ажилтан, олон нийтийн ажилтан, эрүүл мэнд, боловсролын мэргэжилтэн, цагдаа, хороо, сумдын Засаг дарга нараас бүрдсэн олон талт баг (ОТБ) олон нийтийн түвшинд хүүхэд хамгааллын хариу арга хэмжээ авч байна.

Төрөөс 16-аас доош насны бүх хүүхдэд үнэ төлбөргүй эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг. Мөн бүх жирэмсэн эмэгтэйчүүд,

6 ХҮҮХДҮҮД

эхчүүд, нялх хүүхдэд жирэмсний болон төрсний дараах үеийн үзлэгийг улсын санхүүжилтээр эрүүл мэндийн даатгалд хамруулж хийдэг. Монгол Улсүнэтөлбөргүй, заавал эзэмших суурь боловсролын тогтолцоотой. Хүүхдийн Мөнгө Хөтөлбөр нь хүүхдэд нэгдсэн журмаар мөнгө олгож байгаа бөгөөд хүүхдүүдийг мөнгөний ядуурлын нөлөөллөөс хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Нийгмийн халамж, хүүхэд хамгааллын хөтөлбөрүүд нь хөгжлийн бэрхшээлтэй, өнчин, хараа хяналтгүй хүүхдүүд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн зэрэг тодорхой эмзэг бүлгийн хүүхдүүдэд чиглэгддэг.

Хүүхдийн сайн сайхан байдал, эрхийн асуудал эрхэлсэн төрийн бус байгууллагууд

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ) нь хүүхэд залуучуудын асуудал эрхэлсэн төрийн байгууллага юм. Энэ нь 9 дүүрэг, 21 аймагт салбартай. Дүүрэг, аймгийн хэлтэс нь хороо, сумын нийгмийн ажилтнуудад хяналт тавьж, арга зүйн удирдлагаар хангадаг.

ГБХЗХГ нь хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцоонд анхаардаг төрийн бус байгууллага, тэдгээрийн сүлжээнүүдтэй хамтран ажилладаг. 40 гишүүнтэй, Хүүхэд хамгааллын төрийн бус байгууллагуудын сүлжээ нь хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөг, хүний наймаа, хайхрамжгүй хандах, хүчирхийллээс хамгаалах чиглэлээр сурталчилгаа, судалгаа, үйлчилгээ үзүүлдэг. Хамгийн чухал төрийн бус байгууллагууд болон тэдгээрийн сүлжээнд Монголын Хүүхдийн Эрхийн Үндэсний Төв, Монгол Өрх - Сэтгэлзүйн Хүрээлэн, Сургуулийн Нийгмийн Ажилтнуудын Холбоо, Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдийн Эцэг Эхийн Холбоо, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, Хүүхдийн Хөдөлмөрийн Тэвчишгүй Хэлбэрүүдийн Эсрэг Үндэсний Сүлжээ, ЕСРАТ-ын Олон Улсын Байгууллагын Монгол дахь Үндэсний Сүлжээ, Бүх Нийт Боловсролын Төлөө эвсэл, Хүүхдийн Хөгжил, Оролцоо Үндэсний Сүлжээ зэрэг багтана. Тэдгээр ТББ-уудын дийлэнх нь Улаанбаатар хотод байдаг ба хөдөө орон нутагт салбартай нь цөөн.



Photo: Unsplash 2020/ Tom Schuller

7 ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага
Нэгдсэн үндэстний гудамж-14 Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, 14201, Монгол Улс; Утас: + 976 70143100; Имэйл: iomulanbatar@iom.int

Онцгой байдлын ерөнхий газар
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Партизаны гудамж-6, Улаанбаатар, Монгол Улс; Утас: 11-325726; Имэйл: info@menam.gov.mn, contact @nema.gov.mn

Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам
Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-5 Улаанбаатар хот15160, Монгол Улс ; Утас: +976 51 266324 , Имэйл: international@mlsp.gov.mn

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
Чингисийн өргөн чөлөө, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот17032, Монгол Улс; Утас: 1800-1363

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Улаанбаатар хот, Монгол Улс; Имэйл: info@hudulmur-halamj.gov.mn

Улсын бүртгэлийн ерөнхий газар
Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, Цагдийн гудамж, Улаанбаатар хот, Монгол Улс; Утас: +976 1800-1890, Имэйл: contact@burtgel.gov.mn

Цахим хөгжил, харилцаа холбооны яам
Ш/х-785, Төв шуудан, Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг, 15160-00268, Улаанбаатар хот, Монгол Улс Имэйл: e-mongolia@ema.gov.mn

Халдварт өвчин судлалын үндэсний төв
Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Нам Ян Жүгийн гудамж, Улаанбаатар хот, Монгол Улс; Утас: 976-11-458699, Имэйл: info@nccd.gov.mn , www.nccd.gov.mn

Хавдар судлалын үндэсний төв
Нам Ян Жу гудамж, Баянзүрх дүүрэг 13370, Улаанбаатар хот, Монгол Улс ; Утас: 72724000

Нийслэлийн түргэн тусламжийн төв
Чин Ван Чагдаржавын гудамж, Улаанбаатар, Монгол Улс; Утас: 103

Нийгмийн даатгалын ерөнхий газар
Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 13/17, Улаанбаатар хот211238; Утас: 7777-1289 328030 321162; И-мэйл: undeg@ndaatgal.mn

Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв /Дүнжингарав салбар/
Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 26 дугаар хороо, Дүнжингарав худалдааны төвийн D2 блок; Утас: 75751200

Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв/Мишээл салбар/
Улаанбаатар хот Хан-уул дүүрэг 2 дугаар хороо, Мишээл барилгын их дэлгүүрийн баруун жигүүр Б блок; Утас: 75851200

Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв /Драгон салбар/
Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг 29 дүгээр хороо, Драгон төвийн зүүн жигүүр; Утас: 75771200



8 ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Буцаж ирэхээсээ өмнө авах арга хэмжээ

- **Гэр бүл:** Буцаж ирэх талаар гэр бүлийн гишүүддээ хэлж, аялалтай холбоотой зүйлийн талаар ярилцах.
- **Явахын өмнөх чиг баримжаа олгох сургалтад шаардлагатай бол хамрагдах:** энэхүү сургалтаар та нислэгийн мэдээлэл, дамжин суух, ирсний дараах алхмуудын талаар мэдээлэл авах боломжтой.
- **Онлайн сургалтад хамрагдах:** эх орондоо эргэн суурьшихад туслах онлайн сургалтад хамрагдах. Үүнд та www.skillup.mn цахим хуудсаар орж, имэйл хаягаараа бүртгүүлсээр 8 нэр төрлийн үнэ төлбөргүй сургалтад хамрагдах боломжтой.
- **Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (IOM) нь Нийслэлийн Хүний Хөгжлийн Төв, Skillup, TomYo компаниудтай хамтран шилжин суурьшигчдад эргэн нутагшихад зориулсан мэдээллээр хангах, тэдэнд Монгол улсад хөдөлмөр эрхлэх, гарааны бизнес эхлүүлэх талаар мэдлэг мэдээлэл олгох зорилгоор 8 нэр төрлийн цахим сургалтуудыг хүргэж байна.**
- **Сургалтууд олон нийтэд нээлттэй бөгөөд хэн ч үнэ төлбөргүйгээр доорх 3 платформуудаар дамжин хүлээн авч үзэх боломжтой:**

1) Skillup.mn цахим сургалтын платформ

2) TomYo Skills гар утасны аппликэйшн

3) Нийслэлийн Хүний Хөгжлийн Төвийн цахим сургалтын платформ

Буцаж ирсэн даруйдаа авах арга хэмжээ

- **Иргэний үнэмлэх:** www.e-mongolia.mn цахим хуудсаар дамжуулан хүчинтэй үнэмлэх авах хүсэлт гаргана
- **Буцаж ирэх:** Монгол Улсын иргэн ямар нэг байгууллагад бүртгүүлэх шаардлагагүй.
- **Нийгмийн халамж:** Тэтгэврийн даатгал/ажилтны тэтгэврийн төлөвлөгөөг ажил олгогчоос гаргадаг. Өмнө бүртгүүлсэн бол дахин бүртгүүлэх шаардлагагүй. Бүртгэлтэй дүүргийнхээ Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Хэлтэстэй холбогдож нийгмийн халамжийн үйлчилгээ авах боломжтой эсэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл аварай.
- **Эрүүл мэндийн даатгал:** Эрүүл мэндийн даатгалын статусаа www.emd.gov.mn сайтаас шалгана уу. Улсын эрүүл мэндийн даатгалд Монгол Улсын иргэн бүр заавал хамрагдана. Хэрэв та даатгалд хамрагдаагүй бол Эрүүл Мэндийн Даатгалын Газрын төвийн болон орон нутгийн салбарт хандаж, худалдаж аварай.
- **Хүүхдээ товлोलт дархлаажуулалтын хамруулах:** Манай улсад заавал хийгдэх дархлаажуулалтыг хүн амд үнэ төлбөргүйгээр явуулдаг ба дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу хийдэг байна. Заавал хийгдэх дархлаажуулалтад 10 гаруй өвчнөөс сэргийлэх 6 төрлийн вакцин багтдаг.

More information:
www.ReturningfromGermany.de

Scan here:

